



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн “Хөтөлийн цемент шохой” ТӨХК-ийн хувьчлалын талаар авах арга хэмжээний тухай 124 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн “Хувьчлалыг хүчингүйд тооцох, компанийн эрх, эд хөрөнгийг хүлээн авах тухай” 108 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 108 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Цемент шохой” ХК-ийн удирдлагын эрх, хөрөнгийг хүлээлцэх, бүртгэн авах, бичиг баримтад хяналт шалгалт хийх, үйлдвэрийн үйл ажиллагааг хэвийн түвшинд явуулах арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч

-Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын
хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ

Гишүүд:

-Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн
дарга Д.Нарангэрэл

-Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн
мэргэжилтэн Н.Ган-Эрдэнэ

-Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын
хэлтсийн мэргэжилтэн Г.Дэлгэрмаа

-Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн
мэргэжилтэн Э.Дуламсүрэн

-Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн
мэргэжилтэн Д.Батболд

-Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн
мэргэжилтэн Р.Ширчинням

-Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн
мэргэжилтэн А.Алтаншагай

132005083

ТӨБЗГ тушаал-/2022

-Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
Л.Нарантуяа

-Захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
Д.Цэрэнлхам

-Захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
Т.Мөнхбаяр

Нарийн бичгийн дарга: -Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын
хэлтсийн мэргэжилтэн Д.Одмаа


2. Ажлын хэсгийн удирдамжийг хавсралтын ёсоор баталсугай.

3.Томилолтын зардлын төсвийг холбогдох зардлын сангаас гаргахыг
Ерөнхий нягтлан бодогч /Ц.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.

4. Ажлын хэсгийн шийдвэрлэсэн асуудал, боловсруулсан саналыг тухай бүр
газрын даргад танилцуулж, нэгдсэн дүгнэлт, тайланг 2022 оны 04 дүгээр сарын
25-ны өдрийн дотор багтаан танилцуулахыг Ажлын хэсэг /Ц.Баяр-Эрдэнэ/-т үүрэг
болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ



Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын даргын 2022
оны 03 дугаар сарын 24-ний өдрийн
А/25 тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

1.1. Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 124 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах.

1.2. “Цемент шохой” ХК-ийн удирдлагын эрх, хөрөнгийг хүлээлцэх, бүртгэн авах, бичиг баримтад хяналт шалгалт хийх, үйлдвэрийн үйл ажиллагааг хэвийн түвшинд явуулах.

Хоёр. Ажлын хэсгийн гүйцэтгэх ажлын чиглэл

Ажлын хэсэг нь шийдвэрлэсэн асуудал, боловсруулсан саналыг тухай бүр газрын даргад танилцуулж, нэгдсэн дүгнэлт, тайлан гаргана.

2.1. “Цемент шохой” ХК-ийн хөрөнгийн тооллого хийж, эд хөрөнгийг хүлээлцэх, бүртгэлд авах ажлыг зохион байгуулж шийдвэрлүүлэх, баримтын шалгалт хийж дүгнэлт гаргах.

2.2. “Цемент шохой” ХК-ийн санхүүгийн байдал, авлага, өр төлбөрийн асуудлыг судлан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, тайлан, дүгнэлт гаргах.

2.3. “Цемент шохой” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгөд хуваагдах “Хөтөл” ХХК-ийн /хуучин нэрээр “Бэйзмент” ХХК/ эзэмших хувьцааг төрийн эзэмшилд бүртгүүлэн баталгаажуулах.

2.4. “Цемент шохой” ХК-ийн удирдлагын эрх, хөрөнгийг төрд буцаан авах үйл ажиллагааг зохион байгуулах, дүрэм, бүтэц, орон тоог шинэчлэх, үйлдвэрийн хэвийн үйл ажиллагаанд шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллах.

Гурав. Үр дүн, хугацаа

3.1 Ажлын хэсэг нэгдсэн дүгнэлт, тайлан гарган 2022 оны 04 дүгээр сард багтаан газрын удирдлагад танилцуулна.